

БУМАН ДУСАЛ ББСБ

2025 оны 12-р сарын 31-нээр тасалбар
болгосон тайлант жилийн
Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан

АГУУЛГА

Хуудас

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

4

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

5

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг болгож, бид аудитын туршид мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримталсан болно. Мөн түүнчлэн бид:

- Залилан болон алдаанаас үүсч болохуйц санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлон үнэлж, уг эрсдэлүүдэд тохирох аудитын горимуудыг боловсруулан гүйцэтгэж, аудитын дүгнэлтийн үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг. Учир нь залилангийн үед хуйвалдаан, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл хэрэгжүүлэх явдлууд тохиолдсон байж болдог.
- Аудитын горимуудыг сонгохтой холбоотойгоор дотоод хяналтуудыг судалдаг ба энэ нь Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгогүй болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон удирдлагын бэлтгэсэн нягтлан бодох бүртгэлийн таамаглал болон холбогдох тодруулгуудын бодитой байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн тасралтгүй байх нөхцөлийг үргэлжлүүлэн хангах Компанийн чадварт мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал болон материаллаг тодорхой бус байдал үүссэн эсэхийг үнэлдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал байгаа гэж үзвэл аудиторын дүгнэлт болон санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулдаг ба уг тодруулгууд нь зохистой биш гэж үзсэн тохиолдолд бид дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь манай аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэсэн байдаг. Хэдий тийм боловч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал нь Компанийн үйл ажиллагаагаа явуулахад нь саад учруулж болох юм.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлдэг. Үүнд тодруулгаас гадна санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг үнэлэхийн тулд ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.

Аудитор нь засаглах эрх бүхий этгээдтэй зөвхөн аудитын ажлын цар хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад илэрсэн ач холбогдол бүхий асуудлуудаар холбогддог ба үүнд аудитын үеэр аудиторын илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц алдаа болон дутагдал орно.

Баталсан:



Б.Анхтайван

Гүйцэтгэх захирал, Аудитын Партнер, МНБ

Релаэнс Секюритиз Аудит ХХК

2026 оны 3-р сарын 27

БУМАН ДУСАЛ ББСБ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31

Төгрөгөөр

Үзүүлэлт	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	939,279,391	500,717,287
Зээл	4	25,091,089,915	39,073,076,436
Бусад санхүүгийн хөрөнгө	5	-	56,434,206
Санхүүгийн хөрөнгийн дүн		26,030,369,306	39,630,227,929
Татвар, НДШ-ийн авлага	6	1,100,000	21,033,246
Үндсэн хөрөнгө	7	49,089,051	172,872,830
Биет бус хөрөнгө	8	51,062,738	55,252,078
Бусад санхүүгийн бус хөрөнгө	9	8,353,141	197,517,901
Санхүүгийн бус хөрөнгийн дүн		109,604,930	446,676,055
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		26,139,974,236	40,076,903,984
ӨР ТӨЛБӨР			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	10	8,444,698,550	9,497,271,010
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	11	6,913,014,663	6,006,110,950
Бусад эх үүсвэр	12	-	4,996,949,577
Бусад санхүүгийн өр төлбөр	13	44,764,204	54,428,567
Санхүүгийн өр төлбөрийн дүн		15,402,477,417	20,554,760,104
Татвар, НДШ-ийн өр төлбөр	14	254,120,833	300,083,011
Бусад санхүүгийн бус өр төлбөр	15	-	20,582,452
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн		254,120,833	320,665,463
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		15,656,598,250	20,875,425,567
ӨМЧ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	16	6,112,320,000	14,458,770,000
Өмчийн бусад хэсэг	17	3,683,000	150,000,000
Хуримтлагдсан ашиг, алдагдал		4,367,372,986	4,592,708,417
НИЙТ ӨМЧИЙН ДҮН		10,483,375,986	19,201,478,417
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		26,139,974,236	40,076,903,984

БУМАН ДУСАЛ ББСБ
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31- НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

Төгрөгөөр

Орлого, зардлын зүйл	Тодруулга	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
Хүүгийн орлого			
Банканд байршуулсан хөрөнгийн хүү		11,209,709	12,235,387
Зээлийн хүү		6,201,197,843	11,009,793,587
Хүүгийн орлогын дүн		6,212,407,552	11,022,028,974
Хүүгийн зардал			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		1,102,559,119	1,626,401,518
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		654,813,137	2,253,579,175
Бонд, өрийн бичиг		-	139,726,027
Бусад		-	13,388,549
Хүүгийн зардлын дүн		1,757,372,256	4,033,095,269
Хүүгийн цэвэр орлого		4,455,035,296	6,988,933,705
Эрсдэлийн сангийн зардал	18	494,747,571	299,188,515
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		3,960,287,725	6,689,745,190
Бусад орлого		286,382,649	375,508,976
Хүүгийн бус орлого	19	90,678,365	117,688,636
Бусад орлого, олз	20	195,704,284	257,820,340
Бусад зардал		789,123,627	1,793,366,649
Хүүгийн бус зардал	21	737,218,815	1,748,606,589
Бусад зардал, гарз	22	51,904,812	44,760,060
Татварын өмнөх ашиг, алдагдал		3,457,546,747	5,271,887,517
Орлогын татварын зардал	23	350,236,282	529,194,788
Татварын дараах ашиг, алдагдал		3,107,310,465	4,742,692,729
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн		3,107,310,465	4,742,692,729

БУМАН ДУСАЛ ББСБ
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31- НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

Төгрөгөөр

Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2024 ОНЫ 1-Р САРЫН 1-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ	5,265,540,000	3,683,000	3,178,103,021	8,447,326,021
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	3,107,310,465	3,107,310,465
Өмчид гарсан өөрчлөлт	846,780,000	-	-	846,780,000
Хуваарилсан ногдол ашиг	-	-	(1,918,040,500)	(1,918,040,500)
2024 ОНЫ 12-Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ	6,112,320,000	3,683,000	4,367,372,986	10,483,375,986
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	4,742,692,729	4,742,692,729
Өмчид гарсан өөрчлөлт	8,346,450,000	146,317,000	(150,000,000)	8,342,767,000
Хуваарилсан ногдол ашиг	-	-	(4,367,357,298)	(4,367,357,298)
2025 ОНЫ 12-Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ	14,458,770,000	150,000,000	4,592,708,417	19,201,478,417

БУМАН ДУСАЛ ББСБ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2025 ОНЫ 12 САРЫН 31- НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	24,916,184,130	46,554,120,900
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	4,584,724,580	6,942,168,493
Бусад	17,146,749,294	129,924,023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	46,647,658,004	53,626,213,416
Олгосон зээл	31,710,917,000	49,623,531,710
Буцаан олгосон итгэлцэл, үр шим	1,385,343,481	4,733,842,035
Ажиллагсдад олгосон	967,650,000	773,506,328
Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	570,303,248	1,384,969,082
Ашиглалтын зардалд төлсөн	3,687,450	25,245,704
Бусад	17,106,652,583	734,305,297
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	51,744,553,762	57,275,400,156
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,096,895,758)	(3,649,186,740)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулснаас хүлээн авсан	7,000,000	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	7,000,000	-
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	38,554,700	176,126,204
Үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	156,165,000
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	38,554,700	332,291,204
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(31,554,700)	(332,291,204)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Банк, санхүүгийн байгууллагын зээлээс хүлээн авсан	28,663,394,611	35,462,764,668
Өрийн бичиг гаргаснаас хүлээн авсан	-	5,000,000,000
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	1,700,000,000
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	28,663,394,611	42,162,764,668
Банк, санхүүгийн байгууллагын зээлд төлсөн	23,281,127,577	38,619,848,828
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	23,281,127,577	38,619,848,828
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,382,267,034	3,542,915,840
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	253,816,576	(438,562,104)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	685,462,815	939,279,391
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	939,279,391	500,717,287